

“ТАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ”

Л.Булганхангай¹, Ц.Баясгалан²

¹ОБС-ийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн ахлах багш, ахмад

²УА-ийн удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор(Ph.D),
ахлах дэслэгч

Цахим шуудан:bulgankhangai365@gmail.com

Хураангуй: Орчин үеийн дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ)-уудад хэд хэдэн асуудал, бэрхшээл тулгараад байгаагийн дотор өнөөгийн нийгмийн хөгжил, хувьсалд нийцүүлэн хэрэгцээ шаардлагыг дагах шаардлагатай болсон.

Түлхүүр үг: Сургалт, идэвхжүүлэлт, сонсогч-суралцагч, оролцогч тал, Smart-PLS-3.0, SPSS-23, үнэлгээ

Энэхүү судалгааны ажил нь сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа сургалтын идэвхтэй аргуудыг хэрхэн дэмжих, түүнийг хэрэгжүүлэх тухай өгүүлнэ. Судалгааны ажлаараа, суралцагчдад мэргэжлийн суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлүүдийн талаар үндсэн ойлголт, төсөөллийг олгохдоо багш нар уламжлалт заах аргыг хэрэглэхээс илүүтэйгээр харилцан ярилцах, бодит жишээнээс суралцах, асуудал дэвшүүлэх, асуудлыг шийдвэрлэх, дүрд орлон тоглох, оролцоог дэмжих зэрэг аргыг хэрэглэснээр сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй, бүтээлч байх боломжийг сургалтын арга зүйд хэрэглэх нь илүүтэй байгаа эсэхийг судлахыг хичээсэн.

Судалгааны ажлын явцад суралцагч, сонсогчдыг хариуцлагатай байлгах, бүтээлчээр сэтгэх, багаараа харилцан ярилцах гэх мэт суралцахуйн чадваруудыг хөгжүүлэх зорилгоор сургалтын идэвхтэй аргыг хэрэгжүүлэх үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхийн тулд тусгайлан бэлтгэн боловсруулсан асуумжаар судалгаа авсан. Ийнхүү идэвхтэй сургалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, асуудлыг хөндөхдөө гарааны болон эцсийн судалгааг авсан.

Идэвхтэй сургалтын явцад тухайн цагийн байдалд боловсруулалт хийх, асуудал шийдвэрлэхэд суурилсан сургалтыг багийн үйл ажиллагааны оролцоотой хослуулах, орчин үед эрэлт хэрэгцээ өндөр байгаа технологитой хослуулан сургалтын үйл ажиллагаа явуулах нь суралцагчдын хэрэгцээ болж өсөж байгаа нь бидний судалгааны ажлын гүйцэтгэлээр тогтоогдсон. Судалгаанд идэвхтэй сургалтад хамрагдсан Дотоод Хэргийн Их Сургуулийн Онцгой байдлын сургуулийн 641, 643 дугаар дамжааны 40 сонсогч оролцож,

судалгааны үр дүнг Smart-PLS-3.0, SPSS-23 програм, Excel програмаар жишин харьцуулах, дүгнэх, нэгтгэх аргыг хэрэглэн боловсруулсан.

Гарааны судалгаанд үндэслэн сургалтын үйл ажиллагаанд суралцагчдын идэвх оролцоог үнэлэх үнэлэмжийн эцсийн судалгааг 2021-2022 оны хичээлийн жилийн нэгдүгээр улиралд танхимаар явагдаж буй сургалтын үйл явцыг үнэлүүлэн чанарын судалгааг цахимаар авч боловсруулалт хийн гарааны судалгааны зарим үзүүлэлттэй харьцуулан шинжилсэн.

Бидний эцсийн судалгаанд ДХИС-ийн **438** сонсогч хамрагдсан. Энэхүү судалгааг идэвхтэй сургалтын явцад суралцагчдад ямар хүчин зүйл хэрэгцээтэй байгааг тодруулах, ямар хүчин зүйл нь шаардлагатай байгааг илрүүлэхийн тулд хувьсагч бүрийн далд хувьсагчдыг илэрхийлсэн асуултыг давхцалгүйгээр, тухайн хувьсагчаа үнэлүүлэх боломжийг ханган авч судалгааны загварт нарийвчлан тусгасан. Ингэснээрээ, сургалтын идэвхтэй аргад нэн шаардлагатай байгаа хүчин зүйлийн үнэлгээ бага байвал тэрхүү хүчин зүйлийг нэмэгдүүлэх талаар санал болгон дэвшүүлсэн.

Бидний хувьд, сургалтын байгууллага бол бизнесийн байгууллагын нэг хэлбэр бөгөөд, суралцагч оюутнуудыг идэвхжүүлснээр тэдний суралцах болон сургалтын үр дүнд ахиц гаргах боломжтой гэж үзэн Сургалтын үйл ажиллагаанд суралцагчдын идэвхи оролцоог үнэлэх шинжилгээ” сэдвээ томъёолсон. Энэхүү сэдвийг сонгосноор, бусад судлаачдын ажлаас ялгагдах байдлыг чанарын судалгаагаар шинжилгээ хийхийн тулд онолд үндэслэн загвар гаргасан, тухайн загварын таамаглалыг батлах оролдлого хийсэн, санал болгож буй загварт SMART PLS-3.0 програмаар боловсруулалт хийж эх олонлогийн өгөгдөлд хүчин зүйлийн шинжилгээ, хувьсагчийн хамаарлын шинжилгээ, замын шинжилгээг нэг зэрэг хийн таамаглалыг олон талаас нь шинжилж үр дүнг нэгтгэн гаргасан гэж үзэж байна.

Судалгааны ажлын ач холбогдол

Сургалтын үйл ажиллагаа, идэвхтэй сургалт, идэвхжүүлэлт, сургалтад оролцох оролцооны талаарх онолын чиг хандлагын уламжлалт болон орчин үеийн үзэл баримтлалыг судалж, тодорхой дүгнэлт хийсэн нь онолын ач холбогдлыг илэрхийлсэн.

Идэвхтэй сургалтын үйл ажиллагааг тодорхойлох, түүнд нөлөөлөх олон хүчин зүйлийн хувьсагч, хамаарал, тулгамдсан асуудлыг хөндөн таамаглал дэвшүүлж, загвар боловсруулан суралцагчдын төлөөллийн оролцоотойгоор чанарын судалгаа, математик арга зүйгээр цогц байдлаар дагнан судалсан нь практик ач холбогдлыг гаргасан. Үүнд:

1. Боловсролын салбарын сургалтын үйл ажилгааны өнөөгийн байдлын үр дүн ямар төвшинд байгаа нь тодорхойлогдоно.

2. Дээд боловсролын салбарт хэрэгжиж байгаа сургалтын хөтөлбөрийг амжилттай, чанартай байлгах үүднээс идэвхтэй сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийн таамаглал дэвшүүлсэн, загвар санал болгосон тоон болон чанарын бодит судалгаа хийгдэнэ.
3. Гарааны судалгаа болон эцсийн судалгаа тус бүрт харьцуулалт хийн идэвхтэй сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхой болгож хэрэгжиж байгаа хөтөлбөрт санал гаргана.
4. Идэвхтэй сургалтын арга, үйл ажиллагааг дэмжих, хэрэгжүүлэхэд бэлтгэх үе шаттай хөтөлбөр бий болж хэрэгжинэ.

Судалгааны арга зүй: Судалгааны ажил гүйцэтгэхдээ нийгмийн шинжлэх ухааны судалгааны ерөнхий болон тусгай арга болох мэдээлэл цуглуулах өргөн хүрээний анхдагч болон хоёрдогч мэдээлэлд үндэслэн дараах аргуудыг ашигласан. Үүнд:

- Асуулгын арга
- Ажиглалтын арга
- Нэгтгэх түүвэрлэх арга
- Задлан шинжлэх арга
- Баримт бичгийн боловсруулалт хийх арга зүй зэрэг аргаар

хамаарлын нөхцөл байдлыг SMART-PLS 3.0, SPSS-25.0 програм хангамжаар тоон болон чанарын хавсарсан аргыг хэрэглэн дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны ажлын шинэлэг тал: ДХИС-ийн сонсогч, суралцагчдыг хамарсан гарааны болон эцсийн судалгааг цахимаар болон хэвлэмэл цаасан чанарын судалгааны арга зүйгээр таамаглал болгон дэвшүүлсэн загварыг батлахаар шинжлэж судалгааны ажлын үр дүнгээс санал зөвлөмж боловсруулсан нь шинэлэг, давуу тал болсон.

Сургалтын үйл ажиллагаа, идэвхтэй сургалтын онол арга зүй

Монгол Улсын төрөөс “Боловсролын талаар баримтлах бодлого” хэмээх баримт бичигт боловсролын нийгмийн үнэлэмжийг тодорхойлохдоо Боловсрол бол Монгол Улсын тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдлын баталгаа, хөгжил дэвшлийн эх сурвалж мөн. Иймд боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэсэн байдаг.

Боловсролын агуулгыг тодорхойлсон эрдэмтдийн үзэл хандлагаас авч үзвэл:


И.Ф.Харламов: “Боловсролын агуулга нь сургалтын явцад суралцагчид зайлшгүй эзэмших ёстой шинжлэх ухааны мэдлэг, чадвар, дадал мөн ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, гоо сайхны үзэл санааны тогтолцоо юм.”

Б.Т.Лихачев: “Боловсролын агуулга нь орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшинд тохирсон шинжлэх ухаан нийгмийн харилцаа,

үйлдвэрлэлийн ерөнхий үндэс болгон сурган хүмүүжүүлэх зүй боловсруулсан мэдлэг, чадвар, дадлын нийлбэр мөн.”¹⁰ Эдгээр эрдэмтдийн дүгнэлтээс харахад боловсрол нь нийгэм болон хувь хүний амьдрах чадвар гэж үзэх хандлага ажиглагдаж байна.

“Сургалтын үйл явц, үйл ажиллагаа гэж юу вэ?” гэсэн асуулт маргааны бай болсоор л байна. Процесс гэдэг нь ямар нэг үйл ажиллагаа явагдах буюу субъект тодорхой үйлдлийг ухамсартай хийж гүйцэтгэн үүний үр дүнд субъектэд зохих өөрчлөлт гарна гэсэн санаа агуулсан ухагдахуун. Сургалтын үйл ажиллагаа гэдэг бол сургах, сурах үйл, үйлдэл, үйл ажиллагааны явц, үр дүнд багшийн чадвар, сурагчийн мэдлэг чадвар төлөвшилд ахиц, тогтвортой өөрчлөлт.

Зураг 1. Суралцах арга барил эзэмших чадвар:



2; Jackson 2013.

Hard skills /техникийн болон үүргийн чадвар/: Мэргэжлийн хүрээнд заавал мэдэх үндсэн мэдлэг, Мэдлэгээ ашиглан гүйцэтгэх хийх чадвар, Онолын мэдлэг

Soft skills /хувь хүний хандлага, зан үйл/: Харилцааны ур чадвар, багаар ажиллах ур чадвар, зохион байгууллалтын ур чадвар, манлайлах ур чадвар, асуудал шийдвэрлэх чадвар гэх мэт.

Ерөнхийдөө багш оюутны харилцан ажиллах гурван хэлбэрийг ялгаж болох юм.

1. Идэвхгүй хэлбэр: Багш голлон ажиллаж, хичээлийн үйл явцыг удирдана, оюутан идэвхгүй сонсогч байна.
2. Идэвхтэй хэлбэр: Оюутан идэвхтэй оролцоно, багш оюутан хоёр тэгш эрхтэй байна.
3. Интерактив хэлбэр: Оюутнууд багштай төдийгүй өөр хоорондоо идэвхтэй харилцаж, сургалтын үйл явцад оюутнуудын идэвхтэй байдал зонхилно.

¹⁰ Айсмонтас.Б.Б. “Сургалтын онол”. УБ 2003. 74 тал

Сургалтын олон төрлийн аргууд байдаг бөгөөд өнөөг хүртэл улам хөгжиж, төгөлдөржсөөр ирсэн байна. Суралцагчдад мэдлэг, сурах арга барил эзэмшүүлэх, тэдний бие хүн болгон хөгжүүлэн төлөвшүүлэх чиглэл зорилготой эрэмбэлэгдсэн үйлүүд юм гэж Ш.Ичинхорлоо 2002 онд бичсэн “Сурган хүмүүжүүлэх арга, онол ба хэрэглээ” бүтээлдээ Сургалтын аргыг тодорхойлжээ. Идэвхтэй сургалтын аргуудын талаар товч авч үзье (Ш.Ичинхорлоо, 2002).

1. Бүтэцчилсэн танилцуулга арга: Хичээлийн эхэнд сэдвийг ерөнхийд нь танилцуулах энэ арга нь сурагчдын анхаарлыг төвлөрүүлэх, тэдний сурах сонирхлыг бий болгох, гол асуулт, санааг дэвшүүлэх зорилготой байдаг.
2. Үнэт зүйлийн тэнхлэг арга: Дэвшүүлсэн асуудлаар сурагчдын санал бодлыг өрнүүлэхэд Үнэт зүйлийн тэнхлэг аргыг ашигладаг. (Тухайн асуудлаар олон байр суурь байх боломжтойн зэрэгцээ хичээлийн сэдэвтэй уялдаатай байх хэрэгтэйг багш анхаарах ёстой)
3. Түргэн бичвэр арга: Түргэн бичлэг нь сэдвийн дагуу богино хугацаанд өөрийн байр суурийг илэрхийлэн дүгнэж бичих дасгал юм. Түргэн бичлэг нь тухайн үед өөрийн үзэл бодлыг буулгах эссэ бичлэг юм.
4. Суултын самбар арга: Асуултын самбар гэдэг нь хэлэлцүүлгийн үед сурагчдаас дэвшүүлсэн асуултуудыг том хуудас цаасанд тэмдэглэж ангийн хананд байрлуулна гэсэн үг юм.
5. Асуулт дэвшүүлэх нь арга: Асуулт дэвшүүлэх аргыг (Pearce, 1999, 2003) хичээлийн жилийн эхэнд танилцах дасгал болгон ашиглах боломжтой юм.
6. Чиглүүлэгтэй уншлага: Зохиол ба мэдээлэл бүхий текст уншиж, ойлгоход сурагчдад туслах энэ аргыг хичээлийн мэдлэг бүтээх үе шатанд ашигладаг.
7. Чиглүүлэгтэй уншлага – Сэтгэн бодохуйн дасгал (Stauffer, 1970): Зохиол уншиж ойлгоход сурагчдад их тус болдог арга юм.

Идэвхжүүлэлт, түүний үүрэг, ангилал

Идэвхжүүлэлт гэдэг бол хүн өөрийн болон байгууллагынхаа нэгдмэл зорилгод хүрэхийн тулд өөрийгөө болон бусдыг өдөөн түлхэх үйл ажиллагаа юм (Б.Амаржаргал, 2013).

Монгол дахь идэвхжүүлэлтийн онолын үзэл баримтлал:

Идэвхжүүлэлтийн талаарх асуудал зөвхөн менежментийн шинжлэх ухаанд судлагдаад хязгаарлагддаггүй. Маркетинг, үйлдвэрлэлийн салбар өргөн судлагддаг, үр дүнгээ өгдөг юм.

Орчин үеийн бизнесийн ертөнцөд маркетинг, зар сурталчилгаа, идэвхжүүлэлт, сурталчилгааны бусад чиглэлд ажиллаж буй хүмүүст зөвхөн өөрийн мэргэжсэн чиглэлээр хязгаарлахгүй маркетингийн харилцааны олон

төрлийн арга хэрэглүүрийн талаар ойлголттой байж, тэдгээрийг хэрэглэдэг байх шаардлага тулгарч байна.

Дараах хүснэгтэд идэвхжүүлэлтийн талаар салбар салбарын эрдэмтдийн өгсөн тодорхойлолтыг нэгтгэн харуулсан.

Хүснэгт 1. Идэвхжүүлэлтийн талаарх тодорхойлолт.¹¹


Эдийн засгийн их толь бичигт	1. Ямар нэгэн шийдвэр, үйлдлийг гүйцэтгэхийн тулд тайлбар өгөх, учирлал гаргахыг мотиваци буюу сэдэлжүүлэлт гэнэ. 2. нэгэн зорилгод хүрэхийн тулд явуулах үйл ажиллагаа руу хүнийг өдөөж, түүнийг тэрхүү үйл ажиллагаанд хүсэл сонирхолтой болгох, мэдрэмжээрээ шинэ санал, санаа гаргах үйлдэл хийх аргуудтай болгох явдлыг мотиваци гэнэ.
Зарим мэргэжилтнүүд	Ямар нэгэн шийдвэр, үйлдэлд ашигтай байх учир начрыг гаргаж тайлбар өгөх, ямар нэгэн зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө хүнийг өдөөж, үйл ажиллагаанд татагдан оролцох сонирхлыг бий болгох, энэ талаар санаачлага гаргаж байх идэвхжүүлэлтийн аргуудыг багтаасан ойлголт
АНУ-ын эрдэмтэн М.Х.Мексон	Өөрийгөө болон бусдыг өдөөн ажиллуулах үйл явц
ОХУ-ын эрдэмтэн О.С.Виханский	Хүнийг үйлдэл ажиллагаанд өдөөн, уг үйлдлийн хязгаар болон хэлбэрийг зааглан тогтоож улмаар түүнийг тодорхой зорилгод хүргэх чиг баримжаатай болгож буй дотоод гадаад хүчин зүйлсийн цогц нийлбэр мөн.

Эрдэмтэн А.Маслоугийн онол нь хүний идэвхжүүлэлтийн энгийн дүн шинжилгээ хийхэд тохиромжтой хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Учир нь хүн яагаад тодорхой нөхцөл байдалд тодорхой зан байдлыг гаргадаг вэ? гэдгийн танин мэдэх. Мөн шинээр бий болж буй нөхцөлд ямар зан байдал гаргах вэ? гэдгийг урьдчилан мэдэж болдгоороо онцлог байдаг.

Идэвхтэй сургалтын аргуудыг сонсогчдын сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой тул багаар ажиллах, хэлэлцэх, илтгэх, тоглох, дүрд орлон тоглох зэрэг аргыг хэрэглэж байгаа тул сургалтын идэвхтэй онолын үзэл баримтлал дээр тулгуурлан судалгааны багийн судлаачид дараах таамаглал дэвшүүлж загвар боловсруулж чанарын судалгаа хийлээ

Загвар 2. Сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйл (Гарааны судалгаа)

¹¹ Т.Гэрэлхүү Менежмент, 2014, Улаанбаатар хот




Таамаглал-1: Танхимын сургалтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-2: Хээрийн гаралтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-3: Чиглүүлэх үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.

Хамаарах хувьсагч: Танхимын сургалт, Хээрийн гаралтын үйл ажиллагаа, Чиглүүлэх үйл ажиллагаа. **Үл хамаарах хувьсагч:** Сургалтын үйл ажиллагаа

Загвар 3. Сургалтын оролцоонд нөлөөлөх хүчин зүйл (Эцсийн судалгаа)



Таамаглал-1: Сургалтын үйл ажиллагаа идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-2: Ур чадвар идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.

Таамаглал-3: Багшийн хандлага, харилцаа идэвх оролцооны үнэлгээнд эерэгээр нөлөөлнө.

Хамаарах хувьсагч: Сургалтын үйл ажиллагаа, Ур чадвар, Багшийн хандлага, харилцаа, **Үл хамаарах хувьсагч:** Идэвх оролцооны үнэлгээ

Сургалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал

Онцгой байдлын сургуулийн сургалтын үйл ажиллагаа Дээд боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн өдөр, эчнээ ангийн сургалтыг явуулж байна.

Чанарын судалгааны арга зүй

Бид гарааны судалгааны ажлаараа дараах гурван хувьсагчийн шууд хамаарах хувьсагчаар авч, шууд бус хамаарах нэг хувьсагчийн асуултыг судалгааныха асуумж болгон оролцогчдоос судалгаагаа авсан. Үүнд:

Нэг. Танхимын сургалтын үйл ажиллагааг нийт 6 асуултад багтаан үнэлүүлсэн.

1. Гамшгийн үеийн цагийн байдал ойлгомжтой байсан уу?
2. Багийн хуваарилалтын боломж тэгш байдлыг хангасан уу?
3. Ашиглах сурах бичиг, ном, гарын авлага хангалттай эсэх
4. Гамшгийн цагийн байдал дээр ажиллах бэлтгэл хангагдсан уу?
5. Сургалтын үйл ажиллагааны орчин бүрдсэн байсан уу?
6. Багийн үйл ажиллагаа нь хувь хүний оролцоог хангасан уу?

Хоёр. Хээрийн гаралтын үйл ажиллагаа:

1. Түргэн цугларах дохиогоор ажилласан уу?
2. Хувийн бэлтгэл бэлэн байдлаа хангах боломж олгосон уу?
3. Полигон дээр хийсэн сургалтын үйл ажиллагааны орчин бүрдсэн үү?
4. Хээрийн гаралтын үйл ажиллагаа ойлгомжтой байсан уу?
5. Сургалтын үйл ажиллагааны зэвсэглэмж хангалттай байсан уу?

Гурав. Чиглүүлэх үйл ажиллагаа

1. Мэргэжлийн багш нар заавар өгч байсан уу?
2. Мэргэжлийн багш нар зөвлөмж өгч байсан уу?
3. Сургалтын үйл ажиллагааны ерөнхий удирдамж өгсөн үү?
4. Мэргэжлийн багш нар зөвлөгөө, заавар хангалттай өгсөн үү?
5. Багш нарын зөвлөгөө, оролцоо жигд байсан уу?
6. Уншиж судлах материалын мэдээллийг бэтгэн өгч байсан уу?

Дөрөв. Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл

1. Багийн ахлагч тэгш хуваарилах ур чадвартай уу?
2. Сургалтын явцын цагийн хуваарилалт боломжтой байсан уу?
3. Мэдлэг, ур чадвар, хандлага, оролцоог шударга үнэлсэн үү?
4. Дараагийн хийх ажлын чиглэлийг өгч байсан уу?
5. Бэлтгэл ажил хангах боломж бололцоо хангалттай байсан уу?
6. Сонсогч бүрийн оролцоог үнэлж байсан.

Дээрх асуултуудыг Лайкертын 1-5 хэмжээсээр сургалтын үйл ажиллагаанд аль хувьсагч нь хамаарал өндөртэй байгааг үнэлүүлэн оролцогчдыг хамруулж гарааны судалгаагаа авсан. Судалгааны боловсруулалтын чанарын судалгааны арга зүйгээр боловсруулахдаа SMART PLS 3.0 програм ашигласан.

Судалгааны ажилдаа шалтгаан ба үр дагаварын хамаарлыг нийгмийн шинжлэх ухаанд дүгнэн хоёр ба түүнээс дээш хувьсагч хоорондоо хэрхэн хамааралтай болохыг судалгааны загвараа “хамаарах” болон “үл хамаарах” хувьсагчаар дүрслэн илэрхийлсэн.

Хамаарах хувьсагч гэдэг нь үр нөлөөг тайлбарлаж буй, ажиглаж, хэмжиж байгаа хувьсагч. Өөрөөр хэлбэл, бусад хэмжигдэхүүнээс ихээхэн хамаарч, бие даасан хувьсагчийг туршилтаар удирдсаны үр дүнд хувьсагчид өөрчлөгдөх төлөвтэй байдаг таамаглаж буй нөлөө юм. Үл хамаарах хувьсагч гэдэг нь бие даасан хувьсагч буюу хамаарч буй хувьсагчийг тооцох, хянах боломжтой шалтгаант хувьсагч. Иймээс тогтвортой бөгөөд бусад хувьсагчуудад нөлөөлөхгүй хувьсагч ч гэдэг. Үл хамаарах хувьсагч нь таамаглаж буй шалтгаан болдог талаас нь илүү тайлбарлан орууллаа.

Бидний гарааны судалгааны ажилдаа, хэмжил зүйн шинжилгээ, хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ, замын шинжилгээг хийж, дараах утгаар тайлбарлахаар онолын үндэслэл ашигласан. Үүнд:

Кронбах альфа (Cronbach's Alpha) утга нь асуултуудын дотоод тогтвортой байдлыг хэмждэг хэмжигдэхүүн, багц зүйл бүлэг болж хоорондоо хэрхэн нягт уялдаатай байгааг илэрхийлдэг, найдварт байдлын хэмжүүр, найдвартай байдлын коэффициент ч гэж нэрлэгддэг. Ли Жозеф Кронбах (1916-2001), хэмжил зүй, туршилтын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан тэрээр найдварт байдлын үзэл баримтлалаа нотолсон. Бүтцийн тэгшитгэлийн загварын найдварт байдлыг корреляцийн матрицаар хэмждэг Кронбах альфа (Cronbach's Alpha) утга нь [0-1] завсарт оршихдоо олон сонголттой эсвэл олон янзын хэмжүүрийн найдварт байдлыг дараах томъёогоор тодорхойлдог (Томьёо №1.).

$$\text{Томьёо №1. } \text{Cronbach's } \alpha = \frac{N \cdot \bar{C}}{U + (N-1) \cdot \bar{C}}$$

Тайлбар: N = зүйлсийн тоо, $\bar{C}$ = зүйлийн хоорондох дундаж хэлбэлзэл, U = дундаж хэлбэлзэл.

Бүтцийн тэгшитгэлийн загварын найдварт байдлыг корреляцийн матрицаар хэмждэг Кронбах альфа байдлын үзүүлэлт, үр дүнг:

- $0.9 \leq \alpha$ маш сайн, $0.8 \leq \alpha \leq 0.9$ сайн, $0.7 \leq \alpha \leq 0.8$ хүлээн авах боломжтой, $0.6 \leq \alpha \leq 0.7$ асуудал байна, $0.5 \leq \alpha \leq 0.6$ хангалтгүй, $\alpha \leq 0.5$ хүлээн авах боломжгүй (Netemeyer, R. G., Bearden, W. O., & Sharma, S., 2003)

Нийлмэл найдвартай байдал (Composite Reliability-CR) нь тогтвортой, найдвартай, үзүүлэлт чанараа нэг янзаар барьж чадахтай холбоотой чанарын ойлголт. Нийлмэл найдвартай байдлыг байгууламжийн найдвартай байдал ч гэж нэрлэдэг. Кронбах альфа шиг дотоод тогтвортой байдал, далд хувьсагчийн ерөнхий найдвартай байдлыг хэмждэг ба томьёо нь дараах байдлаар илэрхийлэгддэг (Томьёо №2.)

$$\text{Томьёо №2. } R^2 = \frac{(\sum_{k=1}^k l_k)^2}{(\sum_{k=1}^k l_k)^2 + \sum_{k=1}^k \text{var}(Ex)}$$

Тайлбар: K- зүйлийн ачааллын хүчин зүйл, i-зүйлийн алдааны хэлбэлзэл

Нийлмэл найдвартай байдлын үр дүнг:

- 0.6 –аас бага байвал үр дүнгүй, судалгааны үр дүнг зөвшөөрөх боломжгүй
- 0.6- 0.7 хүртэл байвал судалгааны үр дүн найдвартай, тохиромжтой үр дүнтэй,
- 0.7-оос илүү бол судалгааны үр дүн маш найдвартай гэж үздэг (Creswell. J, 2003).

Дундаж хэлбэлзэл найдвартай байдал (Average Variance Extracted –AVE) нь хэмжилтийн алдаанаас болж хэлбэлзлийн хэмжээг илэрхийлдэг хэмжигдэхүүн. Дундаж хэлбэлзлийг ялгаж авсан далд хувьсагч бүрийн эерэг квадрат үндэс нь бусад далд хувьсагчтай хамгийн их хамааралтай байх ёстой. Олон тооны дундаж нь ердөө л тоонуудын нийлбэрийг багц дахь бүх утгын тоонд хуваагдан тодорхойлогддог (Томьёо №3.)

$$\text{Томьёо №3. } AVE = \frac{(\sum_{k=1}^k l_k^2)}{K}$$

Тайлбар: K- зүйлийн ачааллын хүчин зүйл, i-зүйлийн алдааны хэлбэлзэл

Дундаж хэлбэлзэл найдвартай байдлын үр дүнг:

- 0.1-0.29 байвал үр дүнгүй, судалгааны үр дүнг зөвшөөрөх боломжгүй
- 0.3-0.49 байвал судалгааны үр дүн найдвар, тохиромж бага
- 0.5-аас илүү бол судалгааны үр дүн маш найдвартай гэж үздэг (Henseler.J, , 2014).

Дээрх нэр томьёо, томьёоны утга, үр дүнг тайлбарласнаар доорх шинжилгээний үр дүнг тооцоолох, үр дүн ямар утгыг илэрхийлж байгааг дүгнэхэд ашигласан.

Замын шинжилгээг олон хувьсагчдын дунд чиглэсэн хамаарлыг тодорхойлоход ашигладаг ба энэхүү шинжилгээг шалтгаан дээр төвлөрсөн олон удаагийн регрессийн хэлбэр гэж тайлбарладаг. Иймээс таамаглаж байгаа хувьсагчдын замын шинжилгээг хийн бүтцийн тэгшитгэлийн загварчлалын үр дүнг тооцон гаргадаг.

Замын шинжилгээ хийх бүтцийн загварын үр дүн П үнэ цэнэ (P value) нь магадлалын тархалтын дундажутга, стандарт хазайлт, Т статистик хэмжигдэхүүний үр дүнгээс ажиглагдсан хэмжээний үр дүнгээс гарах магадлалыг батлах хэмжигдэхүүн. Магадлалт статистикийн хувьд **Т статистик утга 1.96** ба түүнээс дээш байгаа үр дүнг стандарт хэвийн тархалтын 97.5

хувийн цэгийн ойролцоо утгад дөхөх магадлал үнэн бодитыг баталж байгааг илэрхийлж дараах томьёогоор тооцоологддог (Томьёо №:4).

$$\text{Томьёо №:4. } Z = \frac{p-p0}{\sqrt{\frac{p0(1-p0)}{N}}}$$

Тайлбар: $Tr =$ Түүврийн харьцаа, $P0 =$ тэг таамаглалын эзлэх хувь, $N =$ түүврийн хэмжээ

П үнэ цэнийн утгын тайлбар:

- П үнэ цэнэ > 0.05 үр дүн ач холбогдолгүй, таамаглал батлагдахгүй.
- П үнэ цэнэ < 0.01 үр дүн ач холбогдолтой, таамаглал батлагдана.

Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлсэн судалгаа, судалгааны боловсруулалт

Гарааны судалгааны үр дүнд, судалгаанд оролцогчдын мэдээлэлд шинжилгээ хийн, үр дүнгээс дүгнэлт гарган удирдлагад танилцуулан тайлагнах; Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, хөндлөнгийн үнэлгээ хийхэд сонсогчдын өгсөн санал, зөвлөмжийг хэлэлцэх; Судалгааны үр дүн, гарах шийдвэрийг идэвхтэй үйл ажиллагаа зохион байгуулахад тусгах зэрэг нь хүлээгдэж байсан үр дүн болно.

Судалгааны баг сонсогчдын ерөнхий мэдээлэлд бага ач холбогдол өгсөн ба тэдний нас, хүйс зэрэг ерөнхий мэдээллийг авахыг зорилго болгоогүй. Хамгийн гол нь таамаглаж байгаа гурван хүчин зүйлийн далд хувьсагчдаас хайж байгаа асуудлаа тодорхойлохыг хичээсэн.

Хүснэгт 6. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Үйл ажиллагаа	Асуултууд	Асуултын үр дүн	Найдвартай байдлын илрэл	Дундаж утга
Танхимын сургалтын үйл ажиллагаа	Гамшгийн үеийн цагийн байдал ойлгомжтой байсан уу?	0.603	0.745	0.824
	Багийн хуваарилалтын боломж тэгш байдлыг хангасан уу?	0.515		
	Ашиглах сурах бичиг, ном, гарын авлага хангалттай эсэх	0.714		
	Гамшгийн цагийн байдал дээр ажиллах бэлтгэл хангагдсан уу?	0.664		
	Сургалтын үйл ажиллагааны орчин бүрдсэн байсан уу?	0.634		
	Багийн үйл ажиллагаа нь хувь хүний оролцоог хангасан уу?	0.823		
Хээрийн гаралтын үйл ажиллагаа	Түргэн цугларах дохиогоор ажилласан уу?	0.728	0.735	0.789
	Хувийн бэлтгэл бэлэн байдлаа хангах боломж олгосон уу?	0.903		
	Полигон дээр хийсэн сургалтын үйл ажиллагааны орчин бүрдсэн	0.664		

	үү?			
	Хээрийн гаралтын үйл ажиллагаа ойлгомжтой байсан уу?	0.688		
	Сургалтын үйл ажиллагааны зэвсэглэмж хангалттай байсан уу?	0.200		
Чиглүүлэх үйл ажиллагаа	Мэргэжлийн багш нар заавар өгч байсан уу?	0.846	0.906	0.927
	Мэргэжлийн багш нар зөвлөмж өгч байсан уу?	0.855		
	Сургалтын үйл ажиллагааны ерөнхий удирдамж өгсөн үү?	0.817		
	Мэргэжлийн багш нар зөвлөгөө, заавар хангалттай өгсөн үү?	0.841		
	Багш нарын зөвлөгөө, оролцоо жигд байсан уу?	0.843		
	Уншиж судлах материалын мэдээллийг бэтгэн өгч байсан уу?	0.738		
Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн менежмент	Багийн ахлагч тэгш хуваарилах ур чадвартай уу?	0.618	0.648	0.775
	Сургалтын явцын цагийн хуваарилалт боломжтой байсан уу?	0.585		
	Мэдлэг, ур чадвар, хандлага, оролцоог шударга үнэлсэн үү?	0.649		
	Дараагийн хийх ажлын чиглэлийг өгч байсан уу?	0.691		
	Бэлтгэл ажил хангах боломж бололцоо хангалттай байсан уу?	0.193		
	Сонсогч бүрийн оролцоог үнэлж байсан.	0.817		

Тайлбар: Судалгааны үр дүн

Судалгааг сүүлийн үеийн чанарын судалгааны арга зүйд өргөн хэрэглэн олон хүчин зүйлийн шинжилгээний **SMART PLS 3.0** програмаар үр дүнг гаргасан.Үүнд:

1. Судалгааны тоон мэдээллийг тусгайлан тэмдэгтээр кодлож програмд оруулсан.
2. Судалгаанд таамаглал болгон дэвшүүлсэн загварыг програмд таниулсан.
3. Судалгааны мэдээллийн баазыг загвартаа таниулж мэдээллээ баталгаажуулж шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнг танилцуулбал, Танхимын сургалтын үйл ажиллагааг 6 асуултаар судалсан. Асуултуудын утга 0.515-0.823 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.824, дундаж утга 0.443 үр дүнтэй байна. Хээрийн гаралтын үйл ажиллагааг 5 асуултаар судалсан. Асуултуудын утга 0.200-0.903 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал-0.789, дундаж утга 0.460 үр дүнтэй байна. Чиглүүлэх үйл ажиллагааг 6 асуултаар

судалсан. Асуултуудын утга 0.738-0.855 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.927, дундаж утга 0.679 үр дүнтэй байна. Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн менежментийг 6 асуултаар судалсан. Асуултуудын утга 0.193-0.817 утгын хооронд хэлбэлзэж, хувьсагчийн найдвартай байдал 0.775, дундаж утга 0.388 үр дүнтэй байна.

Хүснэгт 7 Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

№	Хүчин зүйлс	Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл	Танхимын сургалтын үйл ажиллагаа	Хээрийн гаралтын үйл ажиллагаа	Чиглүүлэх үйл ажиллагаа
1	Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл	1.000			
2	Танхимын сургалтын үйл ажиллагаа	0.684	1.000		
3	Хээрийн гаралтын үйл ажиллагаа	0.380	0.614	1.000	
4	Чиглүүлэх үйл ажиллагаа	0.579	0.562	0.588	1.000

Тайлбар: Судалгааны үр дүн

Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл хоорондын хамаарал 1.000, сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл болон танхимын сургалтын үйл ажиллагаа 0.684, сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл ба хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал 1.000, сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл ба чиглүүлэх үйл ажиллагаа хоорондын хамаарал 0.579 тус тус хамааралтай байгаагаас хамгийн сайн хамааралтай байгаа сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл, дундаж хамааралтай байгаа нь сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл ба танхимын сургалтын үйл ажиллагаа, чиглүүлэх үйл ажиллагаа хамааралтай байна.

Хамгийн бага хамааралтай нь сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл ба хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал 0.380 үр дүнтэй байна. Танхимын сургалтын үйл ажиллагааны хоорондын хамаарал 1.000, танхимын сургалтын үйл ажиллагаа ба хээрийн гаралтын хамаарал 0.614, танхимын сургалтын үйл ажиллагаа ба чиглүүлэх үйл ажиллагааны хамаарал 0.562, хээрийн гаралтын үйл ажиллагаа хоорондын хамаарал 0.678, хээрийн гаралтын үйл ажиллагаа ба чиглүүлэх үйл ажиллагааны хамаарал 0.588, чиглүүлэх үйл ажиллагааны хоорондын хамаарал 0.824 тус тус үр дүнтэй байна.

Хүснэгт 8 Замын шинжилгээний үр дүн

ТААМАГЛАЛУУД	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	Т статистик утга	Р үнэ цэнэ	Үр Дүн
Таамаглал-1:	0.569	0.196	3.097	0.002	дэмжигдсэн

Танхимын сургалтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.					
Таамаглал-2: Хээрийн гаралтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.	-0.053	0.207	0.973	0.331	дэмжигдсэнгүй
Таамаглал-3: Чиглүүлэх үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.	0.325	0.177	2.017	0.044	дэмжигдсэн

Тайлбар: Судалгааны үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, Таамаглал-1 ба танхимын сургалтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд нөлөөлнө гэсэн таамаглалын Р утга 0.002 үр дүнтэйгээр батлагдлаа. Таамаглал-2 ба хээрийн гаралтын үйл сургалтын үйл ажиллагаанд нөлөөлнө гэсэн таамаглалын Р утга 0.331 үр дүнтэйгээр батлагдсангүй. Таамаглал-3 ба чиглүүлэх үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын Р утга 0.044 үр дүнтэйгээр батлагдлаа. Таамаглал-2-ын хувьд, далд хувьсагчийн утга зарим шаардлагыг бүрэн хангаж чадаагүй үр дүн гарсан.

Сургалтын үйл ажиллагааг оролцоогоор үнэлэх эцсийн судалгааг гарааны судалгааны адил дөрвөн үйл ажиллагааг хамааруулан чанарын судалгаагаар судалсан. Үүнд:

Нэг. Сургалтын үйл ажиллагаа

1. Мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байдал
2. Мэргэжлийн мэдлэгт загвар ашиглаж сурсан байдал
3. Шинжлэх ухааны шинэ арга зүй эзэмшсэн байдал
4. Дадлагаар шаардлагатай зүйлээ бататган сурсан
5. Онол дадлага хосолсон сургалт явагддаг
6. Ажлын байранд дадлагажих сургалт явагдсан эсэх

Хоёр. Ур чадвар:

1. Ерөнхий гадаад хэлний мэдлэгээ сайжруулсан.
2. Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгээ сайжруулсан.
3. Олон улсын судалгааны ажлаас судлах хичээл орж гадаад хэлний мэдлэгт нөлөөлдөг.
4. Илтгэх ур чадвараа сайжруулж хөгжүүлж чадсан эсэх.
5. Харилцааны ур чадвар эзэмшсэн байдал
6. Шийдвэр гаргах ур чадварт суралцаж буй байдал.

Гурав. Багшийн харилцаа, хандлага:

1. Багшийн хандлага нь үр дүнд суурилсан сургалтанд чиглэдэг.
2. Багшийн зөвлөгөө мэргэжлийн өндөр түвшинд байдаг.
3. Багш мэргэжлийн хувьд нийгэм, салбартаа нэр хүнд бүхий судлаач мөн.
4. Багш хичээлд шинэ арга зүй ашиглан сургалтыг бүтээлч үйл ажиллагаа болгодог.
5. Багш мэргэжлийн гадаад хэлний ур чадвартай, судалгаанд гадаад эх үүсвэр ашигладаг.
6. Багш мэргэжлийн чадвар, хандлага, заах аргаараа манлайлагч байдаг.

Дөрөв. Идэвх оролцооны үнэлгээ:

1. Сургалтын явц, хандлага, үр дүн шударга байдаг.
2. Суралцагчдын оролцоог шударга үнэлдэг байдал
3. Суралцагчдыг идэвхжүүлдэг байдал
4. Оролцоогоор урамшуулан үнэлгээ өгдөг байдал
5. Судалгааны ажил, диплом бичихэд багш нар нэмэлт тайлбар зөвлөгөө өгдөг эсэх
6. Суралцагчдыг ойлгох байдал
7. Сургалтын үйл ажиллагаанд оролцоо, санал, хүсэлтийг харгалзах байдал
8. Багш нараас гадна зочин профессор хичээл заадаг эсэх.
9. Сургалтын алба суралцагчдыг хүндэлж харьцдаг эсэх.
10. Хичээлийн бус цагаар багш нар зөвлөгч байдаг эсэх.

Хүснэгт. Хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

№	Үйл ажиллагаа	Сургалтын үйл ажиллагаа	Ур чадвар	Багшийн харилцаа, хандлага	Идэвх оролцооны үнэлгээ
1	Сургалтын үйл ажиллагаа	1.000			
2	Ур чадвар	0.699	1.000		
3	Багшийн харилцаа, хандлага	0.450	0.785	1.000	
4	Идэвх оролцооны үнэлгээ	0.580	0.590	0.758	1.000

Тайлбар: Судалгааны үр дүн

Сургалтын үйл ажиллагаа хувьсагчид хоорондоо хамгийн их хамаарал ба 1.000, сургалтын үйл ажиллагаа ба ур чадвар 0.699, сургалтын үйл ажиллагаа ба багшийн харилцаа хандлага 0.450, сургалтын үйл ажиллагаа ба идэвх оролцооны үнэлгээ 0.580 тус тус хамааралтай байна. Ур чадвар нь хоорондоо 1.000, ур чадвар ба багшийн харилцаа хандлага 0.785, ур чадвар ба идэвх оролцооны үнэлгээ 0.590 тус тус хамааралтай байна. Багшийн харилцаа, хандлага нь хоорондоо 1.000, багшийн харилцаа хандлага ба идэвх оролцооны үнэлгээ 0.758

тус тус хамааралтай байна. Идэвх оролцооны үнэлгээ хоорондоо 1.000 хамааралтай байна.

Хүснэгт . Замын шинжилгээний үр дүн

Таамаглалууд	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	Т статистик утга	Р үнэ цэнэ	Үр дүн
Таамаглал 1. Сургалтын ажиллагаа оролцоонд нөлөөлнө. 1. үйл нь эерэг	0.562	0.106	5.406	0.000	Дэмжигдсэн
Таамаглал 2. Ур чадвар оролцоонд нөлөөлнө. эерэг	0.060	0.118	0.279	0.780	Дэмжигдсэнгүй
Таамаглал 3. Багшийн харилцаа, хандлага нь оролцоонд нөлөөлнө. эерэг	0.165	0.125	1.988	0.002	Дэмжигдсэн

Тайлбар: Судалгааны багийн үр дүн-

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, сургалтын үйл ажиллагаа нь оролцоонд Т статистик утга 5.406, П үнэ цэнэ 0.000 үр дүнтэйгээр таамаглал батлагдсан. Ур чадвар оролцоонд Т статистик утга 0.279, П үнэ цэнэ 0.780 үр дүнтэйгээр таамаглал батлагдсангүй. Багшийн харилцаа хандлага оролцоонд Т статистик утга 1.988, П үнэ цэнэ 0.002 үр дүнтэйгээр таамаглал батлагдсан.

Эцсийн судалгааг 2021-2022 оны хичээлийн жилийн эхний улиралд танхимаар явагдаж буй сургалтын үйл явцыг үнэлүүлэн чанарын судалгааг цахимаар авч боловсруулалт хийсэн. Энэхүү судалгаанд ДХИС-ийн **438** сонсогч нь олон оролцогчдыг хамруулж, төлөөлөх чадварыг бүрэн хангах боломж бүрэн хангагдсан гэж дүгнэж байна. Энэхүү судалгааг идэвхтэй сургалтын явцад суралцагчдад ямар хүчин зүйл хэрэгцээтэй байгааг тодруулах, ямар хүчин зүйл нь шаардлагатай байгааг илрүүлэхийн тулд хувьсагч бүрийн асуултдыг илэрхийлсэн асуултыг давхцалгүйгээр, тухайн хувьсагчаа үнэлүүлэх боломжийг ханган авч судалгааны загварт нарийвчлан тусгасан.

Судалгааны боловсруулалтад асуултууд болох асуулт бүрийг хүснэгтээр харуулсан нь дараа дараагийн судлаачдад суурь судалгаа болох боломжийг нээн өгснөөрөө ач холбогдолтой.

Судалгаанд оролцогчдын хувьд хүйс, дамжааны ангиллыг харьцуулахыг чухалчилаагүй, хамгийн гол нь хувьсагч бүрт өгөх чанарын үнэлгээг анхаарсан нь судалгааг бодит болгосон ач холбогдолтой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Сургалтын үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгааны эх сурвалжийг энэхүү ажилдаа хураангуйлан оруулсан. Мөн судалгааны арга зүйн талаарх тайлбар, хоорондын уялдааг нэр томъёо, тодорхойлолтыг илүү тусгаж өгсөн.

Сургалтын үйл ажиллагаанд суралцагчдыг идэвх оролцоог үнэлэх шинжилгээ сэдэвт энэхүү дипломыг ажлыг бичихийн тулд сургалтын үйл ажиллагаа, идэвхтэй сургалтын онол арга зүйг боловсрол судлалын чиглэлээр дэлгэрэнгүй судаллаа.

Нийгмийн шинжлэх ухаан, менежментийн үндсэн чиг үүргийн нэг болох идэвхжүүлэлтийг үндсэн суурь онол болгон судалсан ба агуулгын онол, процессын онолын хувьд эрдэмтдийн гаргасан онолын үзэл баримтлалыг харьцуулан судалсан. Сургалтын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх хэд хэдэн хувьсагчийг санал болгон таамаглал дэвшүүлж, 2 загвараа боловсруулсан. Үүнд:

Загвар 1: Танхимын сургалтын үйл ажиллагаа, хээрийн сургалтын үйл ажиллагаа, чиглүүлэх сургалтын үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх гурван таамаглал.

Загвар 2: Сургалтын үйл ажиллагаа, ур чадвар, багшийн харилцаа, хандлага сургалтын идэвх оролцоонд эерэг нөлөө үзүүлэх гурван таамаглал тус тус дэвшүүлэн онол д суурилсан загварыг баталсан.

Судалгааны үр дүнгээс харахад, гарааны судалгааны хувьд, нийт гурван таамаглалаас хоёр таамаглал батлагдсан. Харин эцсийн судлагааны хувьд, нийт гурван таамаглалаас хоёр таамаглал батлагдсан. Эндээс манай судалгааны ажлын хувьд таамагласан ажлын үр дүн сайн гэж дүгнэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Чанарын судалгааны хувьд, таамаглал батлагдахгүй байгаа тохиолдолд тухайн хувьсагчийн хасах, хувьсагч дотор байгаа асуултдаас хасалт хийн үр дүнг гаргаж батлах тохиолдол их байдаг. Бид судалгааны ажлаа заавал батлахын тулд бус, ямар хувьсагч, асуултад анхаарал татаж байгаа нээн илрүүлэхийг чухалд үзсэн.

Гарааны судалгааны хувьд, дараах хэд хэдэн асуумж, асуултын үр дүн бидний таамаглаж байсан үр дүн болох 0.7 тоон үзүүлэлтэд хүрээгүй тул цаашид анхаарах нь зүйтэй гэж дүгнэж байна. Үүнд:

- Гамшгийн үеийн цагийн байдал ойлгомжтой байх
- Багийн хуваарилалтын боломж тэгш байдлыг хангах
- Гамшгийн цагийн байдал дээр ажиллах бэлтгэл хангагдсах
- Сургалтын үйл ажиллагааны орчин бүрдүүлэх
- Полигон дээр хийсэн сургалтын үйл ажиллагааны орчин бүрдсэнг хянах

- Хээрийн гаралтын үйл ажиллагаа ойлгомжтой байгааг хянах
- Сургалтын үйл ажиллагааны зэвсэглэмж хангалттай эсэхэд анхаарах
- Багийн ахлагч тэгш хуваарилах ур чадвартай байгааг хянах
- Сургалтын явцын цагийн хуваарилалт боломжтой байсанг үнэлэх
- Мэдлэг, ур чадвар, хандлага, оролцоог шударга үнэлсэнг бататгах
- Дараагийн хийх ажлын чиглэлийг өгч байсанг лавлах
- Бэлтгэл ажил хангах боломж бололцоо хангалттай байсанг хянах

Харин эцсийн судалгааны хувьд, гарааны судалгааны ажилтай харьцуулахад өөр өөр асуулт байгаа хэдий ч хувьсагч бүрт өгөгдсөн асуултын тоо их байсан ч дараах асуумж мөн бидний тооцоолсон 0.7 үр дүнд хүрээгүй тул дараа дараагийн судалгаанд доорх асуултыг ахин бататгах, эсвэл өөр асуултаар сайн үр дүнг гаргах боломжтой гэж үзэж байна. Үүнд:


- Мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байдлыг үнэлэх
- Мэргэжлийн мэдлэгт загвар ашиглаж сурсанг шалгах
- Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгээ сайжруулах
- Олон улсын судалгааны ажлаас судлах хичээл орж гадаад хэлний ур чадварыг нэмэгдүүлэх
- Шийдвэр гаргах ур чадварт суралцаж буй байдалд хяналт тавих
- Багш хичээлд шинэ арга зүй ашиглан сургалтыг бүтээлч үйл ажиллагаа болгох
- Сургалтын явц, хандлага, үр дүн шударга байгааг анхаарах
- Суралцагчдын оролцоог шударга үнэлдэг байдалд хяналт тавих
- Суралцагчдыг идэвхжүүлдэг байх
- Багш нараас гадна зочин профессор хичээл заах
- Сургалтын алба суралцагчдыг хүндэлж харьцах
- Хичээлийн бус цагаар багш нар зөвлөгч байх

Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгааны ажлын хувьд, дараах хэд хэдэн үзүүлэлтийг судалгааны ажлын хязгаарлагдмал тал гэж үзэж байна. Үүнд:


- Гарааны судалгаанд оролцогчдын тоо эцсийн судалгаатай харьцуулахад илт бага оролцогчтой байсан.
- Энэхүү судалгааны ажлын боловсруулалтад 2020-2021, 2021-2022 хичээлийн жилд суралцаж байгаа суралцагчдыг судалгаанд хамруулсан.
- Сургалтын үйл ажиллагааг бүрэн илэрхийлэх олон хүчийн зүйлсийг төлөөлөл болгон загварт таамаглал болгон орруулах боломж бий болгоогүй.

ХАВСРАЛТ



Загвар 2.1. Сургалтын үйл ажиллагааны нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний үр дүн (гарааны судалгаа)

Тайлбар: ca- танхимын сургалтын үйл ажиллагаа, pa- хээрийн гаралтын үйл ажиллагаа, da- чиглүүлэх үйл ажиллагаа, pm- сургалтын тоглолтын гүйцэтгэлийн менежмент



Загвар 2.2.

Сургалтын идэвхтэй, оролцоог үнэлэх үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний үр дүн (Эцсийн судалгаа)

Тайлбар: tra-сургалтын үйл ажиллагаа, skills-ур чадвар, attit-багшийн харилцаа, хандлага, enga-идэвх оролцооны үнэлгээ

Ашигласан материал

1. Боловсорлын тухай хууль, УБ.,2002.
2. Дээд боловсорлын тухай хууль, УБ.,2002.
3. Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

4. МОНГОЛ ХЭЛ ДЭЭР:
5. Амаржаргал, Б. (2013). *Менежмент*. Улаанбаатар хот, Мөнхийн үсэг.
6. Амартогтох, Г. (2016) “*Хүний нөөцийн онол практик*”, Улаанбаатар хот,
7. Галбадрах. Б, *Боловсролын байгууллагын хөгжил*. УБ. 2019 он
8. Жавзан Б., Б.Энхбаяр. *Боловсролын сэтгэл судлал*. УБ.2009 он
9. Ш.Ичинхорлоо. (2002). *Сурган хүмүүжүүлэх арга, онол ба хэрэглээ*. Улаанбаатар хот.
10. Пүрэвдорж. Ч, “*Менежментийн Удирдлага*”, Улаанбаатар хот, 2002 он 291-р хуудас
11. Оюун. Ц. *Их, дээд сургуулийн үйл ажиллагааны онол, арга зүй*. УБ.2015 он
12. Цэнд Н, Г.Батхүрэл Н, ..Ц. Цэцэгмаа нар “Менежмент” 2013 он, УБ